

## Улаанбаатарын Төвийн дулаан хангамжийн төсөл

Улс:	Монгол
Төслийн дугаар:	49511
Бизнесийн салбар:	Хот суурин газар ба байгаль орчны дэд бүтэц
Төрөл:	Төрийн
Байгаль орчны ангилал:	В
Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулах огноо:	2018 оны 12 дугаар сарын 18-ний өдөр
Төлөв:	Концепцийн Хурлаар орсон
Төслийн товч танилцуулга (PSD)-ыг нийтэлсэн огноо:	2018 оны 10 дугаар сарын 1-ний өдөр

### Төслийн танилцуулга

Улаанбаатар Дулааны сүлжээ компани (цаашид “Компани”, эсвэл “УБДС” гэх)-д дамжуулан зээлдүүлэхээр Монгол Улсад олгож буй 10 сая америк доллар (8.3 сая евро)-ын засгийн газрын зээлийн шугам. Компаний Эн тэргүүний хөрөнгө оруулалтын хөтөлбөр ("PIP")-т i) төвийн дулааны шугам сүлжээний сонгогдсон хэсгүүдийг сэргээн засварлах, шинэчлэх, (ii) эрчим хүчний хэмнэлттэй нэмэгдэл насос/шахуургын станц суурилуулах, (iii) төвийн дулааны дэд станцууд ("CHS")-ыг сайжруулах, УБДС-нд шууд холбогдсон барилгуудад бие даасан/автономит дулааны дэд станцууд ("IHS") суурилуулах зэрэг бусад хөрөнгө оруулалт хийх, (iv) хотын хойд хэсэгт үйлчлэх эрчим хүчний шинэ төв байгуулах, (v) цахилгаан эрчим хүчний үнэ доод түвшинд хүрдэг шөнийн цагаар үйлдвэрлэгдсэн дулааны эрчим хүч, эсвэл ДЦС-ийн үйлдвэрлэсэн илүүдэл дулааныг хадгалах төвийн дулаан хуримтлуулагч суурилуулах ажлууд багтаж байна. Төслийг хоёр талын, эсвэл олон талт хандивлагчид, эсвэл Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (эсвэл хандивлагчдын холимог санхүүжилт)-гийн хөрөнгийн буцалтгүй тусламжаар хамтран санхүүжүүлэх бөгөөд энэ тусламжийн хэмжээ нь 5 сая хүртэлх америк доллар (4.5 сая евро) байна.

### Төслийн зорилго

Тус Төсөл нь төвийн дулаан хангамжийн дэд бүтцийг шинэчлэх замаар Компаний үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой.

### Шилжилтийн нөлөөлөл

Төвлөрсөн дулаан хангамжийн системийг сэргээн засварлах ажилд эрчим хүчний хэмнэлттэй насос/шахуурга, хяналтын автомат систем, дулаан хуримтлуулагч зэрэг тоног төхөөрөмж суурилуулах, дулаан хангамжийн систем дэх ус алдалтыг багасгах зорилгоор сонгож авсан хэсгүүдийг сольж шинэчлэх ажил багтаж байна. Шилжилтийн нөлөөллийн эх үүсвэрүүд нь:

- Жишиг болох шинэ үйл хөдлөл, үйл ажиллагааг бодит байдал дээр харуулна.

- Монголд анх удаа дулааны эрчим хүчийг хадгалах дулаан хуримтлуулагч/хураагуур ашиглах тохиолдол болно.
- Бүтцийн өөрчлөлт амжилттай хэрэгжүүлж болохыг харуулна.
- Арилжааны хэлбэрт шилжүүлнэ: Тус Төсөл нь Компаний хөгжилд болон институцийн чадавхийг бий болгоход туслах замаар Монголын холбогдох салбар арилжааны хэлбэрт улам бүр шилжихэд эерэг жишиг нөлөө үзүүлэх болно.

### **Үйлчлүүлэгчийн мэдээлэл**

УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААНЫ СҮЛЖЭЭ КОМПАНИ

### **ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм**

10,000,000.00 америк доллар

### **Төслийн нийт өртөг**

15,000,000.00 америк доллар

### **Байгаль орчин, нийгмийн харилцааны тойм**

Тус Төсөл нь ЕСБХБ-ны 2014 оны Байгаль орчин, нийгмийн харилцааны бодлогын дагуу “В” ангилалд багтсан. Төслийн үр дүнд, эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх, төвийн дулааны үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулах замаар байгаль орчин, нийгмийн ихээхэн үр ашиг гарах юм. Төсөлтэй холбоотой аливаа эрсдэл, сөрөг нөлөөлөл нь зөвхөн байршилтай холбогдон гарч болох бөгөөд Үйлчлүүлэгчийн зүгээс байгаль орчин, нийгмийн харилцааны асуудлуудыг удирдан зохицуулахад хангалттай хүч хөрөнгө зориулсан тохиолдолд тийм эрсдэл, сөрөг нөлөөллийг илрүүлэх, саармагжуулахад хялбар байх юм. Төслийн үр дүнд, эрчим хүчний хэмнэлт нэмэгдэж, системийн халуун ус, дулаан алдагдал багасан, байгаль орчны стандарт, түүний дотор нүүрс хэрэглэдэг холбогдох ДЦС-уудын CO2 ялгаруулалт буурах явдал сайжрах болно. Судалж үзэх гол асуудлууд дотор төвийн дулааны сүлжээний шугам хоолойг солих, орон сууцны барилга байшинд автономит дулааны дэд станц (IHS) суурилуулах, одоогийн бойлоруудын ажиллагааг үндэсний хууль тогтоомж, ЕХ-ны Аж үйлдвэрийн хорт хийн ялгаруулалтыг зохицуулах удирдамж (EU IED), агаарын чанарын стандартуудад нийцүүлэн зэрэг багтаж байна. Техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааны нэг хэсэг болгон Байгаль орчин, нийгмийн харилцааны нарийвчилсан үнэлгээ (ESDD) хийх бөгөөд түүнд Компаний одоогийн ажиллагаа, байгууламжуудад байгаль орчин, нийгмийн харилцааны хараат бус аудит, түүний дотор жендерийн үнэлгээ хийх, Төслийн байгаль орчин, нийгмийн харилцааны нөлөө, ашиг тусыг үнэлэх ажлууд багтана. Төслийн бүтцийг ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (EBRD PRs)-д нийцүүлэх, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг саармагжуулах, ашиг тусыг нь нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, нийгмийн харилцааны үйл ажиллагааны төлөвлөгөө (ESAP), Талуудын оролцооны төлөвлөгөө (SEP) боловсруулан ажиллана.

### **Техник хамтын ажиллагаа**

Техник хамтын ажиллагаа (ТХА)-ны дараахь ажлууд Төсөлд тус дэм болно. Үүнд:

*Зээлийн гэрээнд гарын үсэг зурахын өмнө:*

ТХА 1: Техник, эдийн засгийн үнэлгээ. Үүнд хөрөнгө оруулалтын техник, санхүү, байгаль орчин, нийгмийн харилцааны элементүүд багтана. Энэ ажлын өртөг нь 350,000 евро хүртэл хэмжээтэй байх ба Японы Засгийн газраас санхүүжүүлнэ.

ТХА 2: Олон улсын санхүүгийн тайлангийн стандартууд (IFRS) байгууллагын аудит. Компанийг олон улсын стандартын дагуу аудит хийлгэх ажилтай танилцуулна. Энэ ажлын өртөг нь 50,000 хүртэлх евро байх тооцоотой бөгөөд Орос, Төв Азийн дэд бүтцийн зөвлөх үйлчилгээний төсвөөс санхүүжүүлэхээр хүсэлт тавьсан.

*Зээлийн гэрээнд гарын үсэг зурсны дараа:*

ТХА 3: Тендерийн бэлтгэл ажил хийх, гэрээ байгуулах, хяналт тавих зэрэг төсөл хэрэгжилтийн дэмжлэг үзүүлэх, дээр нь Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ESAP)-г хэрэгжүүлэх. Энэ ажлын өртөг зардал 600,000 хүртэлх евро байх бөгөөд олон улсын аль нэг хандивлагч, эсвэл ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (SSF)-гаас санхүүжүүлэх хүсэлт тавьсан.

ТХА 4: Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх Компаний хөгжлийн хөтөлбөр. Энэ ажлын өртөг зардал 300,000 хүртэлх евро болох тооцоотой бөгөөд олон улсын аль нэг хандивлагч, эсвэл ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сангаас санхүүжүүлэх хүсэлт тавьсан.

### **Компаний холбоо барих мэдээлэл**

Д-р. Д. Бямба-Очир  
ochir@ubds.energy.mn  
+976 11342397

### **Бизнесийн боломжууд**

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээллийг [EBRD Procurement](#) вэбсайтнаас авна уу:

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: [procurement@ebrd.com](mailto:procurement@ebrd.com)

### **Ерөнхий лавлагаа, үйл ажиллагаатай холбоотой асуулт**

ЕСБХБ-ны төслүүдийн худалдан авах ажиллагаанаас бусад асуудлаар лавлагаа мэдээлэл авах хаяг:

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: [projectenquiries@ebrd.com](mailto:projectenquiries@ebrd.com)

### **Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)**

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ) нь ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаархи олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийг хэрхэн ил болгох, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах журмыг тодорхойлдог. Төрийн хэвшлийн захирлуудын зөвлөлийн тайлан илтгэл авах

хүсэлтийг хэрхэн гаргах талаарх мэдээллийг доорх холбоосоор ОНМБ-ын вэб хуудсанд хандан авна уу.

### **Төслийн Гомдлын Газар (ТГГ)**

Төслийн Гомдлын Газар (ТГГ) нь ЕСБХБ-ны эгэх хариуцлагын механизм, арга хэрэгсэл юм. Энэ нь ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүд байгаль орчинд буюу нийгэмд хор хохирол учруулсан эсвэл учруулж болзошгүй гэж үзсэн хувь хүн болон байгууллагын зүгээс гаргасан гомдлыг хараат бусаар хянан үзэх боломж олгодог.

Гомдол хэрхэн гаргах талаар мэдээлэл авахыг хүсвэл [Project Complaint Mechanism](#) вэб хуудсанд хандана уу. ТГГ-ын ажилтан ([pcm@ebrd.com](mailto:pcm@ebrd.com)) гомдол гаргах, гомдлын бүртгэл ба шаардлагын шалгуурт хэрхэн нийцүүлэх тухай асуудлаар таны аливаа асуултанд **ТГГ-ын Үйл ажиллагааны журам -ын** дагуу хариулахад бэлэн байна.